



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 5 дугаар
сарын 21 өдөр

Дугаар А-127

Улаанбаатар
хот

Хүнсний бөөний худалдааны төв
ажиллуулах зөвшөөрөл олгох тухай

1. Нийслэлийн Засаг даргын 1997 оны "Хүнсний бөөний худалдааны төвийн журам батлах тухай" А) 258 тоот захирамжийг үндэслэн хүнсний бөөний төв ажиллуулах зөвшөөрлийг хавсралтанд дурдсан аж ахуйн нэгжүүдэд олгосугай.

2. Орчны тохижилт, ариун цэвэр, эмх цэгц, дэг журмыг зохих шаардлагын дагуу хангах талаар холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллахыг дээрх аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хотын Захирагчийн ажлын алба (н.Гомбожав), хотын Цагдаагийн газар (н.Жамъянсэнгээ) нарт даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1998 оны "Хүнсний бөөний худалдааны төв ажиллуулах зөвшөөрөл олгох тухай" А)58 тоот захирамжийн хавсралтын 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ-2

Ж.НАРАНЦАЦРАЛТ



**ХҮНСНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ ТӨВ
АЖИЛЛУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

Сүхбаатар дүүрэг

1. Үлэмж ХХК-ний хүнсний бөөний төв
2. Хан-Эрдэнэ ХХК-ний хүнсний бөөний төв

Баянгол дүүрэг

1. Бараа солилцоо, хил худалдааны нэгтгэл УҮГ-ын хүнсний бөөний төв